



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,
Утас: 263051, Факс: (976) 7004-3479


2020.01.08 № 0/75
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

Эрчим хүчний яаманд 2019 оны жилийн эцсийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлт, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг хавсралт хүснэгтийн дагуу гарган хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: 5... хуудастай.



Ц.ДАВААСҮРЭН

170600059



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Эрчим хүчний сайдын зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН НЬ: IV. 2019 оны жилийн эцсийн байдлаар иргэд, аж ахуйн нэгжээс Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яаманд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1.Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /М.Батгэрэл/-т даалгав.

2. Иргэд, аж ахуйн нэгжээс Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яаманд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг чиг үүргийн дагуу хүлээж авсан албан тушаалтан эцэслэн шийдвэрлэж, иргэнд хуулийн хугацаанд хариуг өгөх, салбарын үйлдвэр компаниудад шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг заавал авч, бүртгэл хөтлөн ажиллахыг яамны газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгов” гэжээ.

САЙД



Н.ДАВААСҮРЭН

008000040

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
БАЙДЛААР ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖЭЭС ИРҮҮЛСЭН НИЙТ ӨРГӨДӨЛ,
ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Тус яам, иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх ажиллагааг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар хүлээн авсан өргөдөл, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээ, танилцуулгыг тогтоосон журам, хугацааны дотор гаргаж, удирдлагуудад танилцуулан дүгнэлт, шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Тус яаманд 2019 оны жилийн эцэст нийт 444 өргөдөл ирсэнээс 427 өргөдлийг шийдвэрлэсэн үүнээс 19 өргөдлийг хугацаа хэтрүүлж /сунгаж/ шийдвэрлэсэн, 98 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлсэн, 17 өргөдөл шийдвэрлэлтийн хуулийн хугацаа болоогүй /хяналтад/ байна. Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн биелэлт 96.1% хэрэгжилттэй байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тайланг хавсралт 1, 2, 3-аар тус тус гарган хүргүүлж байна.

---ooOoo---



Эрчим хүчний яаманд 2019 оны жилийн байдлаар иргэд, аж ахуйн нэгжээс Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт | Үүнээс: | | | | |
|---|------------------|--|---------|-----------------|----------------|-----------------|-------|
| | | | Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар хандсан | Биечлэн уулзсан | Бусад |
| 1 | Эрчим хүчний яам | 444 | 396 | 42 | 6 | 0 | 0 |

Тайлбар: 11-11 төвөөс шилжиж ирсэн санал хүсэлтийг тайланд оруулаагүй болно.
2020 оны 01 дүгээр сарын 02-ны байдлаар

---ooOoo---

а/75.....тоот албан бичгийн
хоёрдугаар хавсралт



Эрчим хүчний яаманд 2019 оны жилийн эцэст иргэд аж ахуйн нэгжээс Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | | Шийдвэрлэлт |
|---|------------------|--------------------------------|------------------------|--|--|-----------------------------|-------------|
| | | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлсэн | Хугацаа хэтрүүлж /сунгаж/ шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй /хяналтад/ | |
| 1 | Эрчим хүчний яам | 444 | 427 | 98 | 19 | 17 | 96.1 % |

---ooOoo---



Өргөдөл, гомдол санал хүсэлтийн агуулга

| д/д | Байгууллагын нэр | Зонхилж байгаа асуудал / тоо, нийт өргөдөл гомдолд эзлэх хувь / |
|-----|------------------|---|
| 1 | Эрчим хүчний яам | <p>Нийт 444 өргөдлөөс: Хүсэлт – 357/ 80 % Гомдол – 70 / 15.7% Санал – 15 / 3.3% Мэдээлэл- 2 /0.4%</p> <ul style="list-style-type: none"> • Ажилд орох, гарах, чөлөө хүсэх, цалин хөлс,тэтгэвэр тэтгэмж, зэрэг төрийн албан хаагч,түүний ажиллах нөхцөл баталгаатай холбоотой асуудлаар – 156/35.1% • Удирдлагын үйл ажиллагаа , Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 143/32.2% • Түлш эрчим хүчний үйлдвэрлэл, холбоотой асуудлаар-86/19.3% • Тендер, Тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлтэй холбоотой асуудлаар -32/7.2% • Бусад асуудлаар -27/6% <p>➤ 2019 оны жилийн эцэст иргэдээс яаманд болон салбарын үйлдвэр компаниудад ажилд ороход дэмжиж өгөхийг хүссэн өргөдлүүдийг салбарын үйлдвэр, компаниудад уламжлан шийдвэрлүүлсэн, ажилд орох гарах, чөлөө хүсэх төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгаатай холбоотой асуудлаар ирсэн өргөдлийг холбогдох хууль дүрэм журмын хүрээнд хугацаанд нь шийдвэрлэсэн.</p> <p>➤ Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласны дагуу Засгийн үйл ажиллагааг сурталчлан таниулах нээлттэй өдөрлөгийг Эрчим хүчний яам хуваарийн дагуу 09 дүгээр сарын 26-ны өдөр нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, цахилгаан, дулааны эрчим хүчний хангамж, төлбөр, тооцоо болон үнэ тариф, Цахилгаан, дулааны техникийн нөхцөл, Эрчим хүчний барилга угсралтын тусгай зөвшөөрлын талаар иргэдэд мэдээлэл өгч ажилласан.</p> <p>➤ Гэр хорооллын цахилгааны шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөн хүчин чадлыг нэмэгдүүлж 41.964 айл өрхийг 4 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх барилга угсралтын ажил амжилттай үргэлжилж байна. Одоогийн байдлаар гэр хорооллын 20 мянга гаруй айл өрхийг цахилгаанаар халаах боломжийг бүрдүүлж, “Хүчит шонхор” дэд станцыг өнгөрсөн зун ашиглалтад хүлээлгэн өгсөн.</p> |